





2018 оны 11 дүгээр сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 2380 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 23414.5 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 13.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.



ИНФОГРАФИК




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2018 оны арваннэгдүгээр сард 202.9 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.2%-аар буурч, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдлаар 2304.6 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дамжин өнгөрсөн ачаа /тонноор/



Дамжин өнгөрсөн ачаа 2018 оны арваннэгдүгээр сард 289420.9 тн ачсан нь өнгөрсөн оны мөн үеэс 582.7 тн буюу 0.2%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Ачилт- ачааны төрлөөр /2018 оны 11 дүгээр сард/



2018 оны арваннэгдүгээр сард нүүрс, төмрийн хүдэр, барилгын материал, жонш, зэс, молибдений баяжмал, нефтийн бүтээгдэхүүн өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1802.6 мян.тн ачсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 16.3% өссөн байна.

Нүүрс	53%
Төмрийн хүдэр	30%
Барилгын материал	6%
Зэс, молибдений баяжмал	4%
Жонш	4%
Нефтийн бүтээгдэхүүн	3%